



МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26-33-33, E-mail: info@med.gov.mn,
http://www.med.gov.mn


2014. 01. 15 № 3/82
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн
байнгын хороонд тус яамнаас хүргүүлж байх албан
мэдээ, мэдээллийг хуваарь, мэдээллийн төрлийн дагуу
гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт бүгд хуудас.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА *Б.ШИНЭБААТАР* Б.ШИНЭБААТАР



Мамиязав.
Г.Мунуш

2014. 01. 27

030100

**ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНААС ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД
ТАНИЛЦУУЛАХ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ**

2014-01-10

	Мэдээллийн төрөл	Мэдээ, мэдээллийн талаарх танилцуулга
<p>Яамны хэмжээнд зохион байгуулсан ажлын товч танилцуулга</p>	<p>1. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал</p>	<p>Сайдын зөвлөл нийт 7 удаа хуралдаж давхардсан тоогоор 196 асуудал хэлэлцсэн. Хэлэлцсэн асуудлын дагуу яамдын газар, хэлтсүүдэд үүрэг өгч, газар хэлтсүүд үүргийн биелэлт, түүний явцыг тухай бүрт гаргаж өгсөн. Хэлэлцсэн асуудлаас давхардаагүй тоогоор:</p> <ul style="list-style-type: none"> - Хууль, тогтоолтой холбоотой -7 - Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбоотой - 18 - Яамны дотоод ажилтай холбоотой- 22 асуудлыг хэлэлцсэн.
	<p>2. Зохион байгуулсан зарим ажлууд</p>	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий сайдын "Шинэчлэл-сэтгэл гарган хийх ажил" сэдвээр төрийн албан хаагчидтай хийх чуулга уулзалтад яамны ажилтнуудыг зохион байгуулан оролцов. • "Засгийн газрын цом-2013" спортын арга хэмжээнд яамны баг тамирчид амжилттай оролцов. • Монгол Улсын 4 дэх Ерөнхий сайд, төр, нийгмийн зүтгэлтэн, гавъяат эдийн засагч Д. Содномын 82 насны ойн хүндэтгэлийн арга хэмжээг Сангийн яамтай хамтран зохион байгуулав. • Монгол Улсын 13 дах Ерөнхий сайд, төр, нийгмийн зүтгэлтэн, гавъяат эдийн засагч П.Жасрай агсаны 80 насны ойн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулав. • Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөрөнгө оруулалтын газар байгуулагдсантай холбогдуулан яамны орон тоо, бүтцийн асуудалд өөрчлөлт оруулсан.
	<p>3. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байгаа асуудлууд</p>	<ol style="list-style-type: none"> 1. "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх санхүүжилтийн хэлэлцээр /АХБ/, 2. "Төлбөрийн системийн шинэчлэл" төслийн зээлийн хэлэлцээр /АХБ/, <p><u>Тайлбар:</u> Өрийн удирдлагын тухай хууль УИХ-аар батлагдсан тохиолдолд зээлийн хэлэлцээрүүд Засгийн газрын хуралдаан болон УИХ-аар хэлэлцэгдэх болно.</p> <ol style="list-style-type: none"> 3. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам батлуулах асуудал.
	<p>4. 2013 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлууд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2015-2016 оны хөгжлийн төсөөллийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн тооцоог хийх, дунд хугацааны зорилтуудыг тодорхойлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар 2013 оны УИХ-ын хаврын чуулганаар батлуулав. 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2015-2016 оны төсөөллийг нэгтгэн боловсруулж, Засгийн газраас хуулийн дагуу 2013 оны 05 дугаар сарын 1-нд өргөн мэдүүлэв. Үндсэн чиглэлийн төслийг УИХ-ын 2013 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн чуулганаар батлуулав.

3. Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын 2013 оны намрын ээлжит бус чуулганаар хэлэлцүүлэн батлуулав.
4. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын нэгдсэн чуулган, Байнгын хороодын хурлаар хэлэлцүүлэн, улмаар УИХ-ын 2013 оны 10 дугаар сарын 25-ны нэгдсэн чуулганаар батлуулав.
5. Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай болон Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг УИХ-ын 11 дүгээр сарын 15-ны нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн батлуулав.
6. Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2013 оны 6 дугаар сарын 26-ны хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Засгийн газрын гишүүдийн саналыг тусган, улмаар 2013 оны 7 дугаар сарын 04-нд УИХ-д өргөн мэдүүлэв.
7. Орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2013 оны 6 дугаар сарын 26-ны хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, улмаар 2013 оны 7 дугаар сарын 04-нд УИХ-д өргөн мэдүүлэв.
8. "Эдийн засгийн шинэчлэлийн багц хууль-1"-ийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.
9. Монгол Улсын хөрөнгө оруулалтын 2014-2018 оны хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2013 оны 06 дугаар сарын 26-ны хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн барихаар тогтов. Хөтөлбөрийн төслийг УИХ-аар батлуулахтай холбогдуулан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, УИХ-ын тогтоолын төсөл, хуулийн үзэл баримтлалыг боловсруулав.
10. Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүдийг Бодлогын зөвлөл болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, дараах төслүүдийг дэмжин, хэрэгжүүлж байна. Үүнд: Засгийн газрын 2013 оны 80 дугаар тогтоолоор "Тавантолгойн цахилгаан станц" төсөл, Засгийн газрын 2013 оны 81 дүгээр тогтоолоор "Гудамж" төсөл, Засгийн газрын 2013 оны 82 дугаар тогтоолоор "Шинэ төмөр зам" төсөл, Засгийн газрын 2013 оны 96 дугаар тогтоолоор "Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбох" төсөл, Засгийн газрын 2013 оны 118 дугаар тогтоолоор Нийслэлийн орон сууцны дэд бүтцийг сайжруулах төсөл, Засгийн газрын 2013 оны 126 дугаар тогтоолоор Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл, Засгийн газрын 2013 оны 141 дүгээр тогтоолоор Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр төсөл, Өвлийн хүлэмж барих төсөл, Ноосон бүтээгдэхүүний үйлдвэр төсөл, Оёмол бүтээгдэхүүний салбар хөгжүүлэх төсөл, "Байшин үйлдвэрлэх комбинат-1" төслүүдийг хэрэгжүүлэхээр тогтов. Дээрх төслүүдэд салбар нэгжүүд гарган ажиллаж байна.
11. МХЗ-уудын 2011-2012 оны хэрэгжилтийн Үндэсний 5 дахь илтгэлийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар НББСШУ-ны Байнгын хорооны МХЗ-ууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хорооны 2013 оны 11 дүгээр сарын 20-ны хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлэв.

12. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн (мах, сүү, цагаан идээ, малын гаралтай эмийн болон химийн үйлдвэрийн түүхий эд, дайвар бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, гурил, талх, нарийн боов, ус ундаа г.м.)-ийг боловсруулах, хадгалж тээвэрлэх, худалдан борлуулах үйл ажиллагаа явуулах “Сумын үйлдвэрлэл, технологийн парк”-ийг үндэсний хэмжээнд сүлжээ байдлаар байгуулахаар санал боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 226 тогтоолоор батлуулав.
13. “ДЦС-1Ү станцийн үр ашгийг дээшлүүлэх” төслийн зээлийн хэлэлцээрийн тухай,
14. Японы Олон Улсын хамтын ажиллагааны банкны экспортын зээлийн гэрээний ерөнхий хэлэлцээрийн тухай,
15. “Эрүүл мэндийн салбарын хөгжлийн хөтөлбөр-4”-ийн нэмэлт санхүүжүүлэлт болон “Эрүүл мэндийн салбарын хөгжлийн хөтөлбөр-5” төслийн зээлийн хэлэлцээрийн тухай,
16. “Хүнс, тэжээл, нийгмийн халамжийн төсөл-Нэмэлт санхүүжилт” зээлийн хэлэлцээрийн тухай,
17. “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл” зээлийн хэлэлцээрийн тухай,
18. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хэлэлцээрийн тухай,
19. БНХАУ-ын Засгийн газраас олгож буй 500 сая ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийг сунгах тухай,
20. БНХАУ-ын Засгийн газраас олгож буй буцалтгүй тусламжийн хөрөнгийн 10 сая юаныг ашиглан Архангай, Ховд, Баян-Өлгий аймгуудад жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжсэн төсөл хэрэгжүүлэх тухай,
21. Дэлхийн банкны Итгэлцлийн сангийн 11,0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Үйлдвэр, хөдөө аж ахуйн яаманд хэрэгжүүлэх “Хөдөө, аж ахуй, мал аж ахуйн маркетингийн төсөл”-ийн гэрээнд гарын үсэг зурах тухай,
22. ХБНГУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн хэлэлцээрт гарын үсэг зурах тухай,
23. Дэлхийн банкны итгэлцлийн сангийн тусламжтайгаар хэрэгжүүлэх Авилгаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, хяналтыг бэхжүүлэх төслийн гэрээнд гарын үсэг зурах тухай,
24. Экспортыг дэмжих хөтөлбөр батлуулах тухай
25. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 9 дүгээр тогтоолын дагуу “Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх тухай” төслийн санхүүжилтийн зээлийн хэлэлцээр байгуулах, зээлийн батлагаа гаргах асуудлаар Япон улсад ажилласан Ажлын хэсгийн тайлан
26. Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулга,
27. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт,
28. Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам,
29. Туул сонгино усны нөөцийн цогцолбор төслүүдийн концессын гэрээ.
30. “Дулааны 5 дугаар цахилгаан станц” төслийн талаар Засгийн газрын хуралдаанд 3 удаа танилцуулга хийж, хэлэлцүүлсэн.

	<p>31. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх журам батлуулсан.</p> <p>32. Стратегийн салбарт хөрөнгө оруулах хүсэлтэй 6 аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгосон.</p> <p>33. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөрөнгө оруулалтын газар байгуулсан.</p> <p>34. "Засгийн газрын агентлагийн орон тоо батлах тухай" Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 43 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p>35. "Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 14 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах.</p> <p>36. Хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилсон.</p>
<p>5. 2014 онд УИХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа хууль, шийдвэрийн төслүүд</p>	<p>1. Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2016-2017 оны хөгжлийн төсөөллийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн тооцоог хийх, дунд хугацааны зорилтуудыг тодорхойлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, түүнчлэн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2016-2017 оны төсөөллийг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>3. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулж, 2015 төсвийн төсөлд нэгтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>4. "Эдийн засгийн шинэчлэлийн багц хууль-2"-ыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодотголыг хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>7. Монгол Улсын 2014-2018 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл;</p> <p>8. Монгол Улсын худалдааны бодлогын үзэл баримтлал,</p> <p>9. Худалдааны тухай хууль,</p> <p>10. Зарим барааны үнийн зохицуулалтын тухай хууль,</p> <p>11. Соёрхон батлуулах:</p> <p>а/ Азийн хөгжлийн банкын шугамаар хэрэгжүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> • "Хүнс, тэжээл, нийгмийн халамжийн төсөл-Нэмэлт санхүүжилт" зээлийн хэлэлцээр, • "Төлбөрийн системийн шинэчлэл төсөл"-ийн зээлийн хэлэлцээр, • "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн зээлийн хэлэлцээр, • "Дархан хотын цэвэр усны байгууламжийг шинэчлэх төсөл"-ийн зээлийн хэлэлцээр, • "Хөдөлмөр эрхлэх ур чадвар төсөл"-ийн зээлийн хэлэлцээр, • "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл-Нэмэлт санхүүжилт"-ийн зээлийн хэлэлцээр, <p>б/ Япон Улсын Засгийн газраас олгох хөнгөлөлттэй зээлийн шугамаар хэрэгжүүлэх:</p>

<ul style="list-style-type: none"> • Дулааны IV цахилгаан станцын үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн зээлийн хэлэлцээр, в/ Дэлхийн банкны шугамаар хэрэгжүүлэх: • “Экспортыг дэмжих төсөл”-ийн зээлийн хэлэлцээр, г/ бусад • Монгол Улс, Япон Улсын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах тухай, • “Биокомбинат төрийн өмчит үйлдвэрийн газрын шинэчлэл” төслийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын газар, Унгар Улсын Засгийн газрын хоорондын зээлийн хэлэлцээр, • “Баруун бүсийн оношлогоо, эмчилгээний төвийг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг авах тухай Монгол Улс, Бельгийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, • Монгол, Германы Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны 2014 оны хэлэлцээг Улаанбаатар хотноо зохион байгуулж уг Хэлэлцээрээр тохиролцсон төслүүдийг санхүүжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, • Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын “нөхцөлт” зээлийн хэлэлцээр <p><u>Тайлбар:</u> 1. Өрийн удирдлагын тухай хууль УИХ-аар батлагдсан тохиолдолд зээлийн хэлэлцээрүүд Засгийн газрын хуралдаан болон УИХ-аар хэлэлцэгдэх болно. 2. Монгол Улс, Япон Улсын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах тухай асуудал хэлэлцээрийн явц үр дүнгээс шалтгаалах болно.</p> <p>12. Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.</p>	
<p>Концессын тухай хуулийн хэрэгжилт</p>	<p>1. Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ыг шинэчилэн батлуулсан. Мөн Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар “Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд” чиглэлийн хурдны авто зам, “Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор” төслүүдийн концессын гэрээний төслийг хэлэлцүүлж концессын гэрээ байгуулах зөвшөөрлийг авсан.</p> <p>2. “Дулааны Ү дугаар цахилгаан станц” төслийн концессын гэрээг байгуулах ажлын хүрээнд ЭЗХ-ийн болон ЭХ-ний сайдын хамтарсан 2012 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 5/12 тушаалаар ажлын хэсэг шинэчилэн байгуулагдан ажиллаж байна. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр 2 сайдын хамтарсан тушаалаар өөрчлөлт орсон. Засгийн газрын хуралдаанд тус төслийн танилцуулгыг 3 удаа хийсэн. Азийн хөгжлийн банкны зөвлөхүүдийн зөвлөмж болгосон гурван саналаас Засгийн газар “Дулааны Ү цахилгаан станц” төслийн оролцогч хоёр консорциумаас хамгийн сайн эцсийн санал /тодруулга/-ыг авахаар сонгосон тул үнэлгээг дахин хийж Эдийн засгийн хөгжлийн сайдаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтоолын төсөл, танилцуулга, дүгнэлт, хуралдааны тэмдэглэлийг хүргүүлсэн. Засгийн газар, Ерөнхий сайдад “Дулааны Ү цахилгаан станц” төслийн оролцогчдоос авсан хамгийн сайн эцсийн санал /тодруулга/-аар танилцуулга хийсэн. Мөн Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлд тус төслийн ажлын явцын талаарх танилцуулга мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн. Хамгийн сайн эцсийн санал болгосон оролцогч болох “International Power Plc, Sojitz Corporation, Posco Energy, Newscor LLC” консорциумтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан бөгөөд концессын гэрээ байгуулах, гэрээний нөхцөлүүдийг тохирох хэлэлцээрийг хийж байна.</p>

	<p>3. "Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто зам" төслийн концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Нарийн Сухайтаас-Шивээхүрэн боомт хүртэл авто зам барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих ажлын хэсгийг ЭЗХЯ-ны 2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 54 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна. 2014 оны 2 дугаар улиралд замын ажлыг бүрэн дуусган хүлээн авахаар Концессын тухай хуулийн дагуу хяналт тавин ажиллаж байна.</p> <p>4. ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 53 дугаар тушаалаар Могойн голын дулааны цахилгаан станц төслийн концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Концесс эзэмшигч цахилгаан станцын хүчин чадлыг 100 МВт болгох санал гаргасантай холбогдуулан концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар ажлын хэсэг концесс эзэмшигчтэй хэлэлцээ хийж дууссан. Гэрээг Концессын тухай хуулийн дагуу концесс эзэмшигчтэй 2013 оны 6 дугаар сарын 28-ны өдөр шинэчлэн байгуулан ажиллаж байна.</p> <p>5. Холбогдох салбарын яамд, Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлаг Эдийн засгийн хөгжлийн газрын Концессын хэлтэс, аймаг орон нутгийн болон төрийн захиргааны байгууллагуудын холбогдох албаны хүмүүст концесс олгох, хэрэгжүүлэх талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажилласан.</p>
<p>Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилт</p>	<p>1. Хуулийн дагуу чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албад байгуулагдсан.</p> <p>2. "Алтанбулаг" Худалдааны чөлөөт бүс, "Замын-Үүд" Худалдааны чөлөөт бүсэд Мэргэжлийн хяналтын алба байгуулагдсан.</p> <p>2. Чөлөөт бүсүүдийн газрын хэмжээ, хилийн заагийг УИХ-ын тогтоолоор баталгаажуулсан.</p> <p>3. Чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдын зөвлөл байгуулагдсан.</p> <p>4. Улсын төсвийн болон БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө оруулалт, хувийн хөрөнгө оруулалт хийгдэж байна. Одоогийн байдлаар улсын төсвөөс 28.8 тэрбум төгрөг, хувийн хэвшлээс 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. "Замын-Үүд" Худалдааны чөлөөт бүсэд "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 31.3 сая ам долларын хөрөнгө оруулалт хийгдэж дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил явагдаж байна.</p> <p>5. "Алтанбулаг" Худалдааны чөлөөт бүсэд дотоодын цэргийн, "Замын-Үүд" Худалдааны чөлөөт бүсэд хилийн цэргийн харуул хамгаалалтын алба ажиллаж байна.</p> <p>6. "Алтанбулаг" Худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба газрын төлбөрийн орлогын тодорхой хэсгийг Засгийн газрын тогтоолын дагуу орон нутгийн төсөвт оруулж байна.</p> <p>7. Чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэмийн дагуу Чөлөөт бүсэд Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалаалгүй хүн оршин суух, зорчих журам, шалган нэвтрүүлэх хялбарчилсан журам, чөлөөт бүсэд виз олгох журам, чөлөөт бүсэд гаалийн хяналт тавих журам, чөлөөт бүсэд аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх журмууд батлагдан мөрдөгдөж байна.</p> <p>8. Одоогийн байдлаар чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахаар 86 аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлснээс 3 аж ахуйн нэгж хөрөнгө оруулалт хийсэн.</p>

-----О О 0-----